

**ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ**

<https://doi.org/10.5564/mjls.v2i116.5704>



Монгол Улсын дээд шүүхийн Нийт шүүгчийн хуралдааны
2026 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 57 дугаар
тогтоолын хавсралт

ИРГЭНИЙ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамнаас санаачлан боловсруулсан Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төсөлд санал авахаар ирүүлснийг Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж дараах саналыг хүргүүлэхээр тогтлоо.

Олон улсын сайн туршлагад тулгуурлаж иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг хувьд шилжүүлэх алхамыг эхлүүлэх бэлтгэл болгож иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх харилцааг зохицуулахаар иргэний шийдвэр гүйцэтгэлийн бие даасан хуулийн төслийг боловсруулж байгаа хууль санаачлагчийн үзэл баримтлал нь өнөөгийн шаардлага, нийгмийн хэрэгцээнд нийцэж байна. Шинэчлэн найруулсан Иргэний хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслөөр одоо үйлчилж байгаа хуулиар тогтоосон иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бүтэц, тогтолцоонд томоохон өөрчлөлт оруулахаар тусгагдсан байх ба дараах зарчмын болон агуулгын саналтай байна.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлд хүний үндсэн эрх, эрх чөлөөг тунхагласан. Төсөлд төлбөртэй этгээдийн бүртгэлээс гадна хөрөнгө, орлогогүй этгээдийн бүртгэлийг хөтлөх бөгөөд энэхүү бүртгэлд орсноос үүсэх үр дагаврыг төслийн 42.4-т жагсааж оруулсан байна. Эдгээр зохицуулалтууд нь шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд оролцогчийн эрхийг хэт хязгаарласан гэж үзэхээр байна. Үндсэн хуулийн 2 дугаар зүйлд тусгасан хууль дээдлэх болон шударга ёсны зарчмын дагуу үндсэн эрхэд тавих хязгаарлалт тохирсон байна. Иймд шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад төлбөр төлөгч иргэн, хуулийн этгээдийн эдлэх эрхийг хязгаарлах үндэслэл, уг хязгаарлалт нь хууль ёсны зорилгод хүрэхэд буюу төлөх төлбөрийн үүрэгтэй нь уялдаатай, зайлшгүй, тэнцвэртэй байх шалгуурын дагуу нэрлэн заасан бүх хязгаарлалт ямар хэмжээгээр үйлчлэх нь тодорхой байх учиртай.

2. Шийдвэрийг гүйцэтгэх хугацаа хэтрүүлсэн тохиолдолд хариуцлага ногдуулах шинэ зохицуулалт оруулахаар төсөлд тусгажээ. Иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн биелэлт муу байгаа нь олон талын шалтгаантай бөгөөд үүний дотор иргэдийн ядуурал, төлбөрийн чадваргүй байдал томоохон шалтгаан болж байгааг анхаарвал зохино. Нэг талаас хэт замбараагүй, хяналтгүй зээл олголтын тогтолцоо нөгөө талаас иргэдийн төлбөрийн чадавхыг тодорхойлж, санхүүгийн хүндрэлээс гарахад нь туслах, дэм болох бодлогын болон эрх зүйн механизм үгүйгээс шалтгаалсан төлбөрийн чадвар сул иргэдийн тоо нэмэгдэж байгааг шүүхийн практикаас дүгнэж болохоор байна.

Хувь хүнийг төлбөрийн чадваргүйдлээс гарахад хуулийн хүрээнд туслалцаа үзүүлэх ач холбогдол бүхий арга хэрэгслийн тоонд санхүүгийн боловсролыг



дээшлүүлэх, зээлийг сахилга баттай хэрэглэх дадалд суралцахыг төрийн бодлогоор дэмжих явдал багтахын зэрэгцээ төлбөрийн чадваргүй болсон хувь хүнийг хүндрэлээс гарахад нь мэргэжлийн туслалцаа үзүүлэх тогтолцоог хувь хүний төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулиар бий болгодог. Гэвч иргэнийг төлбөрийн чадваргүй гэж тооцох, үр дагаврыг шийдвэрлэх эрх зүйн орчин дутмаг байгаа өнөөгийн нөхцөлд шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг бодит байдалд төлбөрийн чадваргүй болсон иргэдээс эхлүүлбэл дээр дурдсан хариуцлагын механизм үр дүнгээ өгөхгүй. Харин эсрэгээрээ хувь хүн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрал, сэтгэл зүйд томоохон дарамт үүсгэх сөрөг нөлөөтэй.

3. Шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааны оролцогчдын эрх зүйн байдал нь тус харилцааны суурь зохицуулалт боловч бүтцийн хувьд төслийн арван дөрөвдүгээр бүлэгт хамаарч байгаа нь хуулийг системчлэн тайлбарлахад бэрхшээл үүсгэхээр байна. Түүнчлэн энэ бүлэгт заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч хувь хүний эрх зүйн чадамжийн талаарх зохицуулалт бүрэн бус буюу иргэний эрх зүйн зарим болон бүрэн бус чадамжтай иргэний талаарх хэм хэмжээ орхигдсон байна. Системчлэлийн хувьд тус ажиллагааны оролцогчдын талаарх суурь зохицуулалт төслийн нийтлэг үндэслэл хэсэгт байрших нь зүйтэй гэж үзэж байна. /төслийн Арван дөрөвдүгээр бүлэг, төслийн 151 дүгээр зүйлийн 151.2/

4. Төслийн үзэл баримтлалын шинэлэг алхам болох шийдвэр гүйцэтгэлийн шүүгчийн ажиллагаанд зарим талаар тодорхой бус зохицуулалт туссан байна. Тодруулбал, шийдвэр гүйцэтгэлийн шүүгч шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд гаргасан гомдол, эсэргүүцлийг үндэслэн зарим ажиллагааг хийхээр байх боловч гомдол, эсэргүүцлийн агуулгын ялгаа төдийлөн тодорхой бус байгаа нь хууль хэрэглээний ойлгомжгүй, зөрүүтэй байдал үүсэхэд нөлөөлнө. Энэ чиглэлээр төслийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь хэсгийг сайжруулан боловсруулбал зохино. Мөн төсөлд эсэргүүцлийг хангаснаар цааш үргэлжлэх процесс ажиллагаа, үр дагавар тодорхойгүй үлджээ.

5. Төсөлд иргэний шийдвэр гүйцэтгэгчийн гаргасан зөрчил, ёс зүйн талаар бусад этгээдээс гаргасан эсэргүүцлийг шийдвэр гүйцэтгэлийн шүүгч шийдвэрлэхээр тусгасан нь иргэний хэргийн шүүхийн зорилго, чиг үүрэгт нийцэхгүйн зэрэгцээ тус шүүхийн ачааллыг нэмэгдүүлэх үр дагавартай байгааг анхаарвал зохино.

6. Хэдийгээр шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд алдангийн зохицуулалтыг хэт өргөжүүлэн хэрэгжүүлж байгааг зарчмын хувьд дэмжихгүй байгаа боловч төсөлд мөнгөн бус хөрөнгийн талаарх шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хугацаа хэтрүүлсний алдангийг тооцох арга тодорхой бус байгааг дурдах нь зүйтэй. Мөнгөн бус хөрөнгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа нь мөнгөөр илэрхийлэгдэхгүй тул алдангийг суурилан тогтоох анхдагч дүнг хэрхэн тодорхойлохыг нэг мөр болговол зохино.

7. Төсөлд шийдвэр гүйцэтгэлийн шүүгч торгууль ногдуулахаар зохицуулсан байна. Торгууль ногдуулах үндэслэлийг тодруулах шаардлагатай. Мөнгөн хөрөнгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд хугацаа хэтрүүлсний хариуцлагыг хүлээлгэж байгаа тохиолдолд торгуулийн арга хэмжээ дахин авах нь нэг



зөрчилд давхар хариуцлага ногдуулах агуулгатай байж болзошгүй байх ба энэ нь хариуцлага хүлээлгэх зарчимд нийцэж байгаа эсэх, төлбөр төлөгчийн эрх зүй, эдийн засгийн байдалд хэрхэн нөлөөлөх талаарх үндэслэл тодорхойгүй байна.

8. Төсөлд Монгол Улсын дээд шүүх иргэний хэргийн шийдвэр гүйцэтгэгчийн ёс зүйн дүрэм боловсруулж батлахаар тусгасан байгааг дэмжихгүй байна. Учир нь нийгмийн тодорхой чиг үүрэг бүхий этгээдүүд өөрийн ёс зүйн харилцаанд мөрдөх дүрэм журмыг өөрийгөө удирдах байгууллага, эсхүл шууд харьяалах эрх мэдлийн байгууллагаараа дамжуулан тогтоох нь зохистой бөгөөд Улсын дээд шүүх гүйцэтгэх эрх мэдэлд хамаарах албан тушаалтан болох шийдвэр гүйцэтгэгчийн ёс зүйн дүрмийг батлах нь тогтолцооны хувьд төдийлөн оновчтой биш.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААН